
МЭДЭЭ · 2026 оны 10-р сарын 1

# НҮБ ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГҮҮДЭД ИЛҮҮТЭЙ АНХААРАХЫГ ОНЦОЛЛОО




НҮБ-ын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа"-тай холбоотой 15 дахь удаагийн хурал Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотод 2026 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулагдаж байна.

Энэ удаагийн уулзалт, хурал нь "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа болон хууль дээдлэх явдлыг эрчимжүүлэх нь: Дижитал эрин үед хүмүүсийг, эх дэлхийгээ хамгаалъя, тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлье" сэдвийн дор зохион байгуулагдаж, 119 орны төлөөлөл, 5100 гаруй оролцогч оролцож байна. Тус хурал нь:


- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шинэлэг арга барилыг нэвтрүүлэх;

- Хууль сахиулах байгууллагын хүн-төвтэй үйл ажиллагааг сайжруулах;

- Кибер гэмт хэрэг, цахим залилан, хүний наймаа, хүрээлэн буй орчны эсрэг гэх мэт өсөн нэмэгдэж буй гэмт хэргүүдэд илүүтэй анхаарах;

- Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд техник технологийн дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургах зэргээр хамтын ажиллагаанд ахиц дэвшил гаргах гэсэн үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд ололт амжилтаа хуваалцаж, тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байгаа талаар онцолсон байна.

НҮБ-аас Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд Прокурорын байгууллага авлига, мөнгө угаах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллаж байна.




Эх сурвалж: https://prosecutor.mn/post/406